



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Үндэсний аудитын газрын 2009 оны төлөвлөгөөний дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

СОНГУУЛИЙН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон орон
нутгийн ээлжит сонгуульд зориулсан төсвийн хөрөнгийн
зарцуулалт

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын хоёрдугаар газар

Захирал

Д.Ганбилэг

Аудитын менежер

Х.Баярмаа

Ахлах аудитор

С.Сэрчхорол

Шинжээч *Д.Баттулга*

Б.Болормаа

Р.Цолмон

2009 оны 11 дүгээр сар

**Уг тайланг ҮАГ-ын
вэб сайт-аас үзнэ үү:**

www.mnao.pmis.gov.mn

*Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 261885, 263755
дугаарын утас, 323266
дугаарын
факсаар харилцана уу.*

ХАЯГ:

*Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-
46
Монгол Улс*

Товчилсон үгсийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Бүлэг 1 Сонгуулийн зардлыг бодитой төлөвлөөгүй байна	4
• Оршил	4
• Ерөнхийлөгчийн сонгуулийн зарим зардлыг илүү төлөвлөжээ	5
• УИХ-ын сонгуулийн зардлын төлөвлөлт үндэслэл муутай байна	7
Бүлэг 2 Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна	10
• Сонгуулийн зардлын гүйцэтгэлд тавих дотоод хяналт сул байна	10
• Сонгуулийн зардлын тайланг бодитой гаргахгүй байна	12
Дүгнэлт	14
Холбогдох байгууллагын санал	15
Зөвлөмж	17

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
УБГ	Улсын бүртгэлийн газар
ИБМУТ	Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудитор ТҮАГ-аас 2009 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон орон нутгийн ээлжит сонгуульд зориулсан төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүн, тайлагналыг шалгаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ болон орон нутгийн сонгуульд зориулж олгосон төсвийн хөрөнгийг үр дүнтэй төлөвлөж, зарцуулсан эсэх;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ болон орон нутгийн сонгуульд зориулсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалттай эсэх

Хамарсан хүрээ

Аудитад Сонгуулийн Ерөнхий Хороо, нийслэл, зарим аймаг, дүүргийн сонгуулийн тойрог, хэсгийн хороод хамрагдлаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ болон орон нутгийн ээлжит сонгуульд зарцуулсан төсвийн хөрөнгийг түүвэрлэн шалгах;
- СЕХ-ноос гаргасан холбогдох эрхийн актыг судлах;
- Сонгуульд зарцуулах хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой судалгаанд дүн шинжилгээ хийх;
- Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой бараа, ажил үйлчилгээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авсан эсэхийг түүвэрлэн шалгах;
- Сангийн яам болон холбогдох бусад байгууллагын ажилтнуудтай ярилцлага хийж, тодруулга авах;
- ҮСХ болон УБГ (хуучнаар ИБМУТ)-аас сонгуулийн насны хүн амын судалгааг гаргуулж авах;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Сонгуулийн зардлыг бодитой төлөвлөөгүй байна

Оршил

1.1 Ерөнхийлөгч болон УИХ -ын сонгуулийг зохион байгуулахад шаардлагатай сонгогчийн үнэмлэх, саналын хуудас хэвлүүлэх, саналын хайрцаг хийх, санал авах байрыг тохижуулах, сонгуулийн хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, гарын авлага хэвлүүлэх, хүргэх, сургалт, сурталчилгаа, онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал, ажиллагсдын урамшуулал, СЕХ болон тойрог, салбар, хэсгийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль¹-д тусгасан байна.

1.2 Ерөнхийлөгчийн 2009 он, УИХ болон орон нутгийн 2008 оны сонгуульд улсын төсвөөс нийт 11747.4 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 9709.2 сая төгрөг зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийг зардлын нэр төрлөөр нэгтгэн харуулбал:

(сая төгрөгөөр)

№	Зардлын нэр	Төсөв	Хувь	Гүйцэтгэл	Хувь	Хэмнэлт
1	Хоол, урамшуулал	5375.1	45.8	4715.0	48.6	660.1
2	Хэвлэлтийн зардал	1669.7	14.2	1447.3	14.9	222.4
3	Унаа, албан томилолт	1321.9	11.3	1313.8	13.5	8.1
4	Хяналтын камер авах веб хуудас, сурталчилгаа, сургалт, семинар	1689.3	14.4	997.5	10.3	691.8
5	СЕХ болон бусад зардал	820.4	6.9	770.6	7.9	49.8
6	Бичиг хэрэг, шуудан холбоо	528.7	4.5	464.5	4.8	64.2
7	Болзошгүй зардал	342.3	2.9	0.5	0.0	341.8
	Нийт дүн	11747.4	100.0	9709.2	100.0	2038.2

1.3 Нийт зардлын 48.6 хувь буюу 4715.0 сая төгрөгийг сонгуульд ажиллагсдын хоол, урамшуулалд, 14.9 хувь буюу 1447.3 сая төгрөгийг саналын хуудас, сонгогчийн үнэмлэх болон бусад материал хэвлүүлэхэд, 13.5 хувь буюу 1313.8 сая төгрөгийг унаа, албан томилолтод, 10.3 хувь буюу 997.5 сая төгрөгийг хяналтын камер худалдан авах, веб хуудаст нэрийн жагсаалт байрлуулах, сургалт, сурталчилгаа, семинарын зардалд тус тус зарцуулжээ.

1.4 УИХ-ын сонгуулийн тухай хуульд² заасны дагуу саналын хуудас хэвлүүлэх асуудлыг СЕХ-ны хурлаар баталсан журмын дагуу гүйцэтгэдэг байна.

1.5 Сонгуулийн тойрог бүрт сонгуулийн зардлын нэг дансыг төрийн санд байршуулсан байна.

1.6 Ерөнхийлөгчийн сонгуульд 4050.0 сая, УИХ-ын сонгуульд 7282.4 сая (үүнээс аймаг, нийслэлийн тойргийн хороодод 3969.1 сая, СЕХ-нд 3313.3 сая), орон нутгийн сонгуульд 415.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлжээ.

¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 7.1, УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 10.1.1

² УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 44.2-т "Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудасны загвар, тоо, түүнийг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журам болон тэдгээрт тавигдах шаардлагыг санал авах өдрөөс 21 хоногийн өмнө батална"

1.7 Ерөнхийлөгчийн сонгуульд 3997.6 сая, УИХ-ын сонгуульд 5405.1 сая, орон нутгийн сонгуульд 306.5 сая, бүгд 9709.2 сая төгрөг гүйцэтгэлээр зарцуулагджээ.

1.8 Ерөнхийлөгчийн сонгуулиас 52.4 сая, УИХ-ын сонгуулиас 1877.2 сая, орон нутгийн сонгуулиас 108.5 сая, бүгд 2038.2 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн зарим зардлыг илүү төлөвлөжээ



1.9 Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуулийн бэлтгэлийг хангах, удирдан зохион байгуулах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 15.2³ дахь заалтын дагуу сонгуулийн нутаг дэвсгэрийн 22, салбар 338, хэсгийн 1698 хороог байгуулж, эдгээрт 18 363 хүн ажиллахаар төлөвлөж, сонгуулийн насны хүний тоог 1 642 567 (аймаг, нийслэлийн ИТХ-аас авсан) -гоор тооцжээ.

1.10 Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 177 дугаар тогтоолоор Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон сонгогчийн иргэний үнэмлэхийг хянах зорилгоор 1349 ширхэг тусгай тэмдэглэгээний багажийг худалдан авахад Засгийн газрын нөөц сангаас 40.0 сая төгрөг олгохоор шийдвэрлэжээ.

1.11 Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуульд улсын төсвөөс 3997.6 сая төгрөгийг зарцуулсныг зардлаар ангилан харуулбал:

№	Зардлын нэр	(сая төгрөгөөр)			
		Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Хоол, урамшуулал	2033.4	2047.4	51.2	-14.0
2	Хэвлэлтийн зардал	625.6	625.1	15.6	0.4
3	Унаа, албан томилолт	596.3	572.1	14.3	24.2
4	СЕХ-д болон бусад зардал	319.5	296.6	7.4	22.9
5	Бичиг хэрэг, шуудан холбоо	219.3	224.5	5.6	-5.2
6	Сурталчилгаа, сургалт	255.0	215.5	5.4	39.5
7	Тэмдэг хийлгэх	0.9	16.3	0.5	-15.4
	Нийт дүн	4050.0	3997.6	100.0	52.4

1.12 Нийт зардлын дийлэнх хувийг хоол, урамшуулал, хэвлэлийн зардал эзэлж байна. Харин унаа, албан томилолтын зардал 24.2 сая, сурталчилгаа, сургалтын зардал 39.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

1.13 СЕХ-ны 2009 оны 13 дугаар тогтоолоор “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журам”-ын 1-ийн 3⁴-т заасны дагуу Ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудасны тоог нутаг дэвсгэрийн хороодоос ирүүлсэн сонгуулийн насны хүн амын тооноос 5 хувиар өсгөн саналын хуудсыг 1 678 100 ширхэг, сонгогчийн үнэмлэхийг 1740 850 ширхэг хэвлүүлжээ.

³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 15.2-т Сонгуулийн хэсгийн хороод байгуулахдаа тухайн хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчдын тоо, ажлын хэмжээг харгалзан дор дурьдсанаар тогтооно: 1/Тухайн хэсэгт 2000 хүртэл сонгогчтой бол 9, эсхүл 11, 2/ 2001-4000 хүртэл сонгогчтой бол 11, эсхүл 13, 3/4001-6000 хүртэл сонгогчтой бол 13, эсхүл 15

⁴ МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журмын 1-ийн 3-т “Саналын хуудасны тоог аймаг, нийслэлийн дүүрэг тус бүрээр сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоонд үндэслэн Хороо батлах бөгөөд ингэхдээ сонгогчдын шилжилт хөдөлгөөн, саналын хуудаст буруу тэмдэглэл хийж солиулах зэргийг тооцож зохих хэмжээний нөөцтэй байхаар тогтооно”

Үүнийг хүснэгтээр үзүүлбэл,

№	Үзүүлэлт	Сонгогчийн үнэмлэх		Саналын хуудас	
		Хүний тоо	Бүгд үнэ (сая төгрөг)	Хүний тоо	Бүгд үнэ (сая төгрөг)
1	Төлөвлөсөн	1639450	289.0	1598191	258.4
	Нөөц	89200		79909	
	Нийт дүн	1728650		1678100	
2	Гүйцэтгэл	1740850	291.1	1678100	258.4
3	Зөрүү	-12200	-2.1	0	
4	Хүчингүй болсон	47133	7.9	2864	0.4
5	Зарцуулаагүй үлдсэн	203484	34.0	577085	88.9

1.14 Сонгуулийн саналын хуудас, сонгогчийн үнэмлэхээр тооцсон хүний тоо 41 259 -өөр зөрүүтэй, мөн хэвлүүлсэн сонгогчийн үнэмлэх төлөвлөснөөс 12 200-гаар илүү байна.

1.15 Нийт сонгогчийн үнэмлэхний 47 133 ширхэг хүчингүй буюу дахин олгосон, 203 484 ширхэг зарцуулагдаагүй, саналын хуудаснаас 2 864 ширхэг нь хүчингүй, 577 085 ширхэг зарцуулагдаагүй байна.

1.16 Ерөнхийлөгчийн сонгуулийн батлагдсан төсвийг зардлын нэр төрлөөр харьцуулахад зарим зардал хэтэрсэн байна.Тухайлбал,

- *Тусгай тэмдэглэл хийх бахины үнэ 15.4 сая төгрөг*
- *Бичиг хэрэг, шуудан холбоо 5.2 сая төгрөг*
- *Сонгуулийн хороонд ажиллагсдын хоол, урамшуулал 14.0 сая төгрөгөөр тус тус хэтэрчээ.*

1.17 СЕХ-ны 2009 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар Ерөнхийлөгчийн сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо, салбар, хэсгийн хороодын гишүүн тус бүрд олгох мөнгөн урамшууллыг сонгуулийн хэмнэсэн зардлаас гаргах замаар гишүүн тус бүрд 108.0 мянган төгрөг олгохоор шийдвэрлэсэн нь хоол, урамшууллын зардал хэтрэхэд нөлөөлсөн байна.

1.18 “Тусгай тэмдэглэл хийх тухай” СЕХ-ны 2009 оны 31 дүгээр тогтоолын дагуу сонгогчийн иргэний үнэмлэх дээр тусгай тэмдэглэл хийх багаж худалдан авах зардалд олгосон 15.4 сая төгрөг төсөвт тусгагдаагүй байна.


Дархан-Уул аймгийн 1, 9, 12, 14 дүгээр сонгуулийн хэсгийн хороод Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураах байр бэлтгэх зардлыг бичиг хэрэг, шуудан холбооны зардалд зарцуулжээ.

Улсын Их Хурлын сонгуулийн зардлын төлөвлөлт үндэслэл муутай байна

1.19 УИХ-ын сонгуулийн зардлыг 2008 оны төсвийн тухай хуульд 3282.4 сая төгрөгөөр баталсан боловч бараа, шатахууны үнэ өссөн, сонгогчдын нэрсийн жагсаалтыг интернетэд тавих, хэсгийн хороодод видео камер байрлуулахтай холбогдуулан УИХ-ын 2008 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 31, Засгийн газрын

2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 189 дүгээр тогтоолын дагуу 4000.0 сая төгрөгийн тодотгол хийж, 7282.4 сая төгрөгөөр баталжээ.

Зардлын нэр төрлийг графикаар харуулбал:



1.20 Нийт зардлын 46.0 хувь буюу 3341.7 сая төгрөгийг тойрог, хэсгийн хороонд ажиллагсдын хоол, урамшуулалд, 14 хувь буюу 1019.9 сая төгрөгийг хэвлэлийн зардалд, 11 хувь буюу 771.0 сая төгрөгийг хяналтын камер болон веб хуудас шинэчлэхэд зарцуулахаар төлөвлөжээ.

1.21 СЕХ сонгуулийн зардлын төсвийг төлөвлөхдөө холбогдох байгууллага, орон нутгаас нийт хүн ам болон сонгуулийн насны хүн амын судалгааг авсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Ангилал	ҮСХ	ИБМУТ	Аймаг, нийслэлийн ИТХ
1	Аймгийн дүн	987465	940712	968529
2	Нийслэлийн дүн	686266	602725	639656
3	Улсын дүн	1673731	1543437	1608185

1.22 Эндээс үзэхэд ҮСХ-ноос ирүүлсэн сонгуулийн насны хүн амын тоо ИБМУТ (хуучнаар)-өөс ирүүлсэн тооноос **130 294** хүнээр, аймаг, нийслэлийн ИТХ-аас авсан тооноос **65 546** хүнээр илүү байна.

1.23 УИХ-ын сонгуулийн саналын хуудасны тоог төлөвлөхдөө сонгуулийн насны хүн амын тоог 10 хувиар, сонгогчийн үнэмлэхийг 5 хувиар нэмж тооцжээ.

1.24 СЕХ 2008 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн “УИХ-ын 2008 оны сонгуулийн саналын хуудасны загвар тоог батлах тухай” 47 дугаар тогтоолоор аймгийн тойргийн хороодоос ирүүлсэн сонгуулийн насны хүн амын тоог 10 хувиар өсгөж хэвлүүлэхээр шийдвэрлэж 1 664 642 саналын хуудас, 1 656 060 сонгогчийн үнэмлэх хэвлүүлсэн байна.

Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Үзүүлэлт	Сонгогчийн үнэмлэх		Саналын хуудас	
		Хүний тоо	Бүгд үнэ (сая төгрөг)	Хүний тоо	Бүгд үнэ (сая төгрөг)
1	Төлөвлөсөн	1673731	309.3	1673731	568.6
	Нөөц	83686			
	Нийт дүн	1757417		1841104	
2	Гүйцэтгэл	1656060	284.2	1664642	375.8
3	Зөрүү	101357	25.1	176462	192.7
4	Хүчингүй болсон	40713	6.9	24533	5.2
5	Зарцуулаагүй үлдсэн	82784	13.9	479838	100.7

1.25 Төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулбал нийт сонгогчийн үнэмлэхийг 5.8 хувь буюу 101 357 ширхэг, саналын хуудсыг 9.6 хувь буюу 176 462 ширхгээр (54.4 сая төгрөг) илүү тооцож төлөвлөжээ.

1.26 Нийт хэвлүүлсэн сонгогчийн үнэмлэхний 40713 ширхэг хүчингүй болж, 82784 ширхэг зарцуулагдаагүй, саналын хуудасны 24533 ширхэг хүчингүй болж, 479838 ширхэг огт зарцуулагдаагүй үлдсэнээс үзэхэд сонгогчийн үнэмлэх, сонгуулийн саналын хуудас нэмж хэвлүүлэх нөөцийг 3 орчим хувиар тооцож болохоор байна.

1.27 УИХ-ын ээлжит сонгуульд тойргийн хороо 26, салбар хороо 340, хэсгийн хороо 1800 болон эдгээрт нийт 26746 хүн (*хэсгийн хороонд ажиллах хүнийг хуульд заасан дээд хязгаараар 15-аар тооцсон*⁵) ажиллахаар зардлыг төлөвлөснөөс үзэхэд СЕХ салбар хороог 8, хэсгийн хороог 96-гаар, хэсгийн хороонд ажиллагсдыг 6572 хүнээр илүү тооцсон байна. Нэг ажилтанд олгох урамшууллыг 108.0 мянган төгрөгөөр тооцвол 709.8 сая төгрөг илүү төлөвлөжээ.

1.28 УИХ-ын 2008 оны ээлжит сонгуульд зарцуулсан 5405.1 сая төгрөгийн дийлэнх хувийг тойрог, салбар, хэсгийн хороонд ажиллагсдын хоол, урамшуулал, хэвлэлийн зардалд зарцуулжээ.

1.29 СЕХ сонгуулийн үйл ажиллагаанд зориулан 365 ширхэг хяналтын камер (*нэг бүрийг нь 1275.0 мянган төгрөг*)-ыг 465.4 сая төгрөгөөр худалдан авч 21 аймаг, нийслэлийн ИТХ-ын өмчид бүртгэх үүрэг өгснийг аудитын явцад шалгахад Хөвсгөл аймагт олгогдсон 12 ширхэг камерийг ИТХ бүртгэлд тусгаагүй байлаа.

1.30 Сонгуулийн салбар болон тойргийн хороо батлагдсан төсвийг зардал хооронд гүйлгэн зарцуулах, үндсэн хөрөнгө худалдан авахад зарцуулсан тохиолдол гарсан байна. Тухайлбал, Говь-Алтай аймгийн сонгуулийн тойргийн хороо сонгуулийн зориулалттай төсвийн хөрөнгөөр терминал утас, зөөврийн компьютер, сейф, канон зэрэг хөрөнгийг 5.4 сая төгрөгөөр, Дорнод аймгийн сонгуулийн тойргийн хороо 240.0 мянган төгрөгөөр принтер худалдан авсан байна.

1.31 УИХ-ын сонгуулийн хэсгийн хороонд ажиллагсдын тоог илүү тооцсоноос урамшуулалд 674.2 сая, хэвлэлийн зардалд 220.0 сая, хяналтын камер худалдан авах зардалд 255.7 сая, болзошгүй зардалд 350.0 сая төгрөг зарцуулаагүйгээс нийт 1877.2 сая төгрөг хэмнэжээ.

Орон нутгийн сонгуулийн зардал хэмнэгдсэн байна

1.32 УИХ-ын 2008 оны 11, Засгийн газрын 2008 оны 3 дугаар тогтоолоор орон нутгийн 2008 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг 415.0 сая төгрөгөөр тогтоож, 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт оруулан Засгийн газрын нөөц сангаас гаргахаар баталжээ.

⁵ УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 18.2-г "Сонгуулийн хэсгийн хороог байгуулахдаа тухайн хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчдын тоо, ажлын хэмжээг харгалзан дор дурьдсанаар тогтооно. 2000 хүртэл 9, эсхүл 11, 2001-3500 хүртэл сонгогчтой бол 11, эсхүл 13, 3501-ээс дээш сонгогчтой бол 13, эсхүл 15"

1.33 СЕХ-ны 2008 оны 67 дугаар тогтоолоор орон нутгийн 2008 оны ээлжит сонгуульд оролцох хүний тоог 1 673 731-ээр төлөвлөж, саналын хуудасны тоог 10 хувиар өсгөн 1 841 103 ширхгээр тооцжээ.

1.34 Орон нутгийн сонгуулийн зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн бөгөөд аудитад зөвхөн улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт хамрагдлаа.

1.35 Орон нутгийн 2008 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд сонгуулийн хууль, заавар, журмын эмхэтгэл, сурталчилгааны зурагт хуудас хэвлүүлэх, саналын хайрцагны нэг удаагийн лац авах, сурталчилгааны зардал, сонгуулийн баримт бичгийг аймгийн сонгуулийн хороодод хүргэх тээврийн болон семинарын зардалд 306.5 сая төгрөг зарцуулж, 108.5 сая төгрөг хэмнэжээ.

1.36 Энэхүү хэмнэлт нь хэвлэлийн зардлаас 30.6 сая, хэсгийн хороо, саналын хайрцагны лацны тоог багасгаснаас 0.8 сая, сургалтын зардлаас 8.9 сая, сурталчилгааны зардлаас 34.0 сая, томилолт, шагнал, урамшууллын зардлаас 11.0 сая, болзошгүй зардлаас 19.7 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

1.37 Нийслэлд орон нутгийн сонгууль дахин явуулахтай холбогдуулан улсын төсвөөс 495.0 сая төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 519.4 сая төгрөг зарцуулжээ.

1.38 СЕХ-ноос Ерөнхийлөгч, УИХ болон орон нутгийн сонгуулийн зардлыг тооцох гол нөхцөл болох сонгуулийн насны хүн амын тоог холбогдох байгууллагуудаас авч төлөвлөсөн боловч бодитой болж чадаагүй байна.

1.39 Сонгуулийн саналын хуудасны тоог 10 хувиар, сонгогчийн үнэмлэхний тоог 5 хувиар өсгөж байгааг эргэн авч үзэж, хувь хэмжээг бууруулах нь зүйтэй юм.

БҮЛЭГ 2

Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна

Сонгуулийн зардлын гүйцэтгэлд тавих дотоод хяналт сул байна

2.1 Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуульд нийслэлийн нутаг дэвсгэрийн хороо 323.7 сая төгрөг зарцуулсан боловч төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байгаагаас дараахь зөрчил дутагдал илэрсэн байна.

- Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлүүлэхээр “Бит пресс” ХХК-д 2.5 сая төгрөгийг гэрээ хийлгүй шилжүүлжээ.
- Нийслэлийн нутаг дэвсгэрийн хорооны гишүүдэд 1.0 сая төгрөгийн урамшуулал олгосон баримт болон авсан хүний гарын үсэг байхгүй.
- Архивын ажилд 150.0 мянган төгрөгийн гэрээг Нийслэлийн архивын газартай байгуулсан боловч гүйцэтгэл нь гараагүй.
- Нийслэлийн төр захиргааны авто баазын зарим жолооч нарт 234.0 мянган төгрөг илүү олгожээ.

2.2 Нийслэлийн нутаг дэвсгэрийн хорооны санхүүгийн дотоод хяналт хангалтгүйгээс Багануур, Налайх, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн сонгуулийн салбар болон хэсгийн хороодод нийт 6.5 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн байна. Энэ нь сонгуульд ажиллагсдын хоол, урамшууллыг өгөөгүй байхад олгосноор тооцсон, зардлыг илүү болон зөрүүтэй тайлагнасангай холбоотой байна.

2.3 Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7.1.5-д “... сонгуулийн зардлын төсвийг батлагдсан төсвийн хэмжээний дотор хуваарилах, зарцуулалтад хяналт тавих” асуудлыг СЕХ-ны бүрэн эрхэд тусгажээ.

2.4 Гэвч тойргийн хорооноос салбар, хэсгийн хороодод олгосон төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналт хангалтгүй байна.

- Төв аймгийн сонгуулийн хэсгийн хороодод зарцуулсан 140.8 сая төгрөгийн хөрөнгөд аймгийн нутаг дэвсгэрийн хороо хяналт тавиагүйгээс зарим сумын хэсгийн хороонд баримтын бүрдэл дутуу байна.
- Төв аймгийн нутаг дэвсгэрийн хороонд зарцуулсан 8294.4 мянган төгрөгийн зарлагын баримт;
- Сүмбэр сумын сонгуулийн хэсгийн хороонд зарцуулсан 682.0 мянган төгрөгийн шатахууны баримт, 31.0 мянган төгрөгийн томилолтын зардлын болон 2392.3 мянган төгрөгийн зарлагын баримт ;
- Сэргэлэн сумын сонгуулийн хэсгийн хороонд зарцуулсан 7647.6 мянган төгрөгийн зарлагын баримт ;
- Эрдэнэсант сумын сонгуулийн хэсгийн хороонд зарцуулсан 6.8 сая төгрөгийн зарлагын баримт;
- Лүн сумын сонгуулийн хэсгийн хороонд зарцуулсан 5064.2 мянган төгрөгийн зарлагын баримт;

- Өндөрширээт сумын сонгуулийн хэсгийн хороонд зарцуулсан 532.0 мянган төгрөгийн зарлагын баримт материал тус тус алга байна.

2.5 УИХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлийг шалгах явцад анхан шатны баримт, материалын бүрдэл дутуу, нэхэмжлэхээр төлбөр хийгээгүй тохиолдол цөөнгүй гарлаа.Тухайлбал,

- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотой дүрэм, журам, зааврын эмхэтгэлийг хэвлүүлэхээр “Жикомпресс” ХХК-тай, сонгогчийн үнэмлэхийг хэвлүүлэхээр “Мигма принт” ХХК-тай тус тус гэрээ байгуулсан боловч гэрээг дүгнэж баримтжуулаагүй, тухайн материалыг орлого авч зардалд тусгаагүй.
- “Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо” ТББ-аар дамжуулан УИХ-ын сонгуультай холбоотой үйл ажиллагааг мэдээлэх гэрээ байгуулсан боловч мэдээ, материал нийтлэгдсэн баримт материал байхгүй.
- “Дотно” FM-103.6-гаар дамжуулан 5 FM-тэй сонгуулийн сурталчилгааг явуулахаар гэрээ байгуулсан боловч сурталчилгаа хийснийг нотлох баримт байхгүй.
- Салбар хэсгийн хороодод олгосон урамшууллаас хувь хүний орлогын албан татвар суутгаагүй (Төв аймгийн Мөнгөн морьт, Угтаал, Эрдэнэсант сум), суутгасан татварыг төсөвт шилжүүлж холбогдох тооцоо хийгээгүй (Өндөрширээт сум), томилолтын баримт хаагдаагүй, салбар, хэсгийн хороодын гишүүдэд олгосон хоол урамшууллын мөнгөний баримтад гарын үсэг зуруулаагүй (Сүмбэр сум)..
- Анхан шатны баримт материалын бүрдүүлэлт хангалтгүй байхад Төв аймгийн сонгуулийн тойргийн хороо нягтлан бодогчоо гурван удаа нийт 648,0 төгрөгөөр шагнасан.
- Нийслэлийн 9 дүүрэг, Дархан-Уул, Төв аймгийн сонгуулийн тойрог, хэсгийн хороонд ажиллагсад урамшууллыг нэг хүний гарын үсгээр олгосон байна.

2.6 Нийслэлийн сонгуулийн хороо орон нутгийн сонгуулийн хороодод ажиллагсад олгосон урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байлаа.

2.7 Аймаг, орон нутгийн сонгуулийн хорооноос ирүүлсэн зардлын гүйцэтгэлийн тайлан баримт материалаас үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарцуулалтын тайлангүй, санхүүгийн анхан шатны баримтын тоо, мөнгөн дүнг засварласан зөрчил дутагдал гарлаа.Тухайлбал,

- Увс аймгийн Тариалан, Өмнөговь, Тэс, Малчин, Зүүнхангай сумдын сонгуулийн салбар хорооны санхүүгийн баримтад хэсгийн хорооны ажилтнуудад шагнал, холбооны зориулалтаар олгосон ярианы нэгжийн жагсаалтын болон замын хуудсанд зарцуулсан бензиний тоо хэмжээ, автомашины гүйлт зэрэг зарим дүнг засварласан, замын хуудсыг дэлгэрэнгүй хөтлөөгүй, Өлгий, Зүүнхангай сумууд автомашины бензиний зарцуулалтыг өвлийн норм буюу 100 км-т 20 литр шатах тослох материал зарцуулснаар тооцоо хийж, норм хэмжээг баримтлаагүй;
- Нийслэлийн Сонгуулийн хороо автомашины замын хуудсанд явсан километрийг илүү бичсэн;
- Төв аймгийн Сонгуулийн хороонд орон нутгийн сонгуулиар тойргийн хорооны

гишүүдэд олгосон урамшууллын 2,5 сая төгрөг, шатахууны 3,0 сая төгрөг, сумдын санхүүжилтийн дэмжлэгт олгосон 4,4 сая төгрөгийн баримт материал байхгүй.

2.8 СЕХ улсын төсвийн 415.0 сая төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж ирсэн ба орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгөнд хяналт тавих боломжгүй байна.

Сонгуулийн зардлын тайланг бодитой гаргахгүй байна

2.9 Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуульд зарим нутаг дэвсгэрийн хороод СЕХ-оос хүргүүлсэн төсвийн хуваарилалттай ижил дүнгээр зардлын тайланг ирүүлсэн байлаа. Тухайлбал,

- *Архангай аймгийн нутаг дэвсгэрийн хороо 180.3 сая*
- *Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрийн хороо 168.8 сая*
- *Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хороо 189.3 сая*
- *Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрийн хороо 154.1 сая*
- *Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн хороо 130.4 сая*
- *Завхан аймгийн нутаг дэвсгэрийн хороо 182.5 сая*
- *Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хороо 117.8 сая*
- *Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн хороо 115.5 сая*
- *Увс аймгийн нутаг дэвсгэрийн хороо 171.9 сая*
- *Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн хороо 152.8 сая*
- *Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийн хороо 61.3 сая*
- *Орхон аймгийн нутаг дэвсгэрийн хороо 49.1 сая*
- *Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийн хороо 18.9 сая*
- *Нийслэлийн нутаг дэвсгэрийн хороо 323.7 сая төгрөгөөр тус тус тайлагнасан байна.*

2.10 СЕХ гүйцэтгэлээр ирүүлсэн дээрх тайланд ямар нэгэн дүн шинжилгээ хийлгүй шууд нэгтгэн тайлагнасан нь Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-ийн 5¹, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 8², 13 дугаар зүйлийн 1-ийн 2³-т заасныг зөрчиж хяналт тавиагүй байна.

2.11 Мөн УИХ-ын сонгуульд ч дээрх байдал давтагдаж, сонгуулийн тойргийн болон салбар хороодоос ирүүлсэн тайлангаас үзэхэд гүйцэтгэлийг СЕХ-ноос хүргүүлсэн зардлын ангилалтай тулган тааруулж зөрүүгүй гаргасан байлаа. Үүнд:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн УИХ-ын сонгуулийн 21 дүгээр тойрог, Сэлэнгэ аймгийн Орхон, Шаамар, Сайхан, Баянгол, Баруунбүрэн, Сүхбаатар сумдыг нэрлэж болно.

¹ Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-ийн 5-д Хорооны бүрэн эрхийг “Ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн зардлын төсвийг батлагдсан хэмжээний дотор хуваарилах, зарцуулалтад хяналт тавих”

² Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 8-д Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо, түүний бүрэн эрхийг “Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах салбар болон хэсгийн хороонд хуваарилах, зарцуулалтад хяналт тавих”

³ Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-ийн 2-т “Сонгуулийн хороодын санхүүгийн тайланг хянан шалгах”

2.12 СЕХ тойргийн хорооноос ирүүлж байгаа зардлын тайланг хянан хүлээж аваагүй, тайланг үнэн зөв гаргасан эсэхэд дүгнэлт хийгээгүй байна. Тухайлбал,

Баянзүрх дүүргийн тойргийн хороо 3,5 сая төгрөгийн шагнал олгосныг урамшууллын зардалд бичиж тайлагнасан, харилцах болон мөнгөн кассаас зарлага болгож буй зарим баримтууд бүрдэл дутуу, худалдаж авсан материалыг орлогод аваагүй байна.

2.13 Дээрх байдлаас үзэхэд СЕХ Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 13.1.2-т “Сонгуулийн хороодын санхүүгийн тайланг хянан шалгах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

2.14 Орон нутгийн сонгуульд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн тайланг тойрог, хэсгийн хороодоос ирүүлсэн байна. Гэвч,

- *Зарим аймгийн хэсгийн хороодын сонгуулийн зардлын тайлан гарын үсэг, тамга тэмдэггүй;*
- *Төв аймгийн Зуунмод сумын сонгуулийн тойргийн хороо тайлангаа гаргаж ирүүлээгүй, Угтаалцайдам сумаас гаргаж ирүүлсэн тайлан нь гарын үсэггүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй;*
- *Нийслэлийн Сонгуулийн хороо сонгуулийн зардлын тайланг 792.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.*

2.15 Сонгуулийн зарим тойрог, салбар, хэсгийн хороод сонгуулийн зардлын тайланг СЕХ-ноос баталсан маягтын дагуу гаргаж өгсөн боловч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, НББТХуулийн зохих заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байлаа. Тухайлбал,

Нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн сонгуулийн хороод бараа, материал бэлтгэн нийлүүлсэн байгууллагын зарлагын падангүй, гарын үсэг, мөнгөний хүсэлт болон бэлэн мөнгөний зарлагын баримтууд байхгүй, дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй, зарим үед бэлэн мөнгө олгосон жагсаалтгүй, томилолтын хуудсыг хаагаагүй, зөвшөөрлийн цохолтгүй, ажлын гэрээгүй хөлс олгосон, замын тооцооны хуудас, маршрут байхгүй, бараа материалын тайлан гаргаагүй байна.

2.16 СЕХ сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа шууд гэрээ байгуулсан, гэрээний биелэлтэд тавих хяналт сул, гэрээг дүгнэж, гүйцэтгэлийг баталгаажуулаагүй, зарим баримт дутуу байлаа.

2.17 Сонгуулийн тойрог, хэсгийн хороодод зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБУСТХ-ийн дагуу гаргуулж, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Сонгуулийн насны хүн амын тоог үндэслэл муутай, өндөр тогтоосноос зардлаа илүү төлөвлөсөн байна.
- Сонгуулийн саналын хуудас, сонгогчийн үнэмлэхийг 5-10 хувийн нөөцтэйгээр хэвлүүлж байгаагаас зарцуулагдаагүй саналын хуудас, сонгогчийн үнэмлэх их хэмжээгээр үлдэж, үр ашиггүй зардал гарч байна.
- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулсан боловч бараа, материал нийлүүлсэн баримт дутуу, гүйцэтгэлд тавих хяналт сул байна.
- Сонгуулийн зарим тойргийн болон нутаг дэвсгэрийн хороод сонгуулийн зарцуулалтын тайланг гаргаж ирүүлэхдээ батлагдсан зардлын зүйл ангийг төсөвтэй нь ижил дүнгээр мэдээлсэн, СЕХ ирүүлсэн тайланг нь сайтар хянаагүй байна.
- СЕХ, тойргийн хороодоос сонгуулийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.



МОНГОЛ УЛС
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Улаанбаатар-01
Ж.Самбуурын гудамж 11, Засагын ордон 31 байр
Утас 20-29-75, Факс 32-00-75
E-mail: gao@gao.gov.mn
http://www.gao.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
Б.БАТБАЯР ТАНАА

2009.11.04 № 262
талбай _____ -ийг № _____ -г
Тайлангийн тухай

Тайлбар 1-ийг үзнэ
үү.

Тайлбар 2-ыг үзнэ
үү.

Үндэсний аудитын газраас Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон Орон нутгийн Хурлын сонгуулийн төсвийн зарцуулалтад хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийг шалгалтын явцад арилгуулсан тул энэ тухай тайланд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн тайлангийн зөвлөмжид "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу бараа, ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх" талаар заасан нь аливаа сонгуулийн үеэр цаг хугацааны хувьд уг хуулийг баримталж ажиллахад бэрхшээлтэй, хэрэгжих боломжгүй байна. Иймээс ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд сонгуулийн хороод ажил гүйцэтгэх гэрээг хувь хүн, хуулийн этгээдтэй сонгон шалгаруулалтгүйгээр байгуулахыг хуульчилсан бөгөөд Улсын Их Хурал болон Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд дээрх хуулийн агуулгатай адил нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулж байна. Энэ байдлыг харгалзан үзэж зөвлөмжөөс дээрхи заалтыг хасах саналтай байна.



ДАРГА

Handwritten signature

Н.ЛУВСАНЖАВ

000334

ТАЙЛБАР

Тайлбар 1	Монгол Улсын Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын сонгуулиар Дархан-Уул, Төв аймаг, Нийслэлийн нутаг дэвсгэрийн хороо, Багануур, Налайх, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн сонгуулийн хэсгийн зарим хороод сонгуульд ажиллагсдын хоол, урамшууллын мөнгийг баримтгүй болон илүү олгосон, нэг хүний гарын үсгээр өгсөн, зардлыг буруу тайлагнасан зэрэг аудитаар илэрсэн зөрчил дутагдал бүрэн арилаагүй учраас уг саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 2	Саналыг хүлээн авч зөвлөмжид тусгав.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сонгуулийн Ерөнхий Хорооны дарга Н.Лувсанжавт зөвлөж байна.Үүнд:

- Сонгогчдын тоог бодитой тогтоож, мэдээллийн нэгдсэн бааз үүсгэн, онлайн сүлжээнд холбож, сонгуулийн ажилд дэвшилт техник, технологийг нэвтрүүлэх асуудлыг судлан боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- Сонгуулийн саналын хуудас болон сонгогчийн үнэмлэхний нөөцийн хувь хэмжээг оновчтой тогтоох;
- Сонгуулийн үйл ажиллагаанд шаардагдах бараа, ажил, үйлчилгээг худалдан авах оновчтой арга хэлбэрийг судалж, эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- Сонгуулийн тойрог, салбар, хэсгээс ирүүлж байгаа гүйцэтгэлийн тайланг хянаж хүлээн авах, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт материалын бүрдэлт, сонгуулийн зардлын гүйцэтгэлд хяналт тавих тогтолцоо бий болгох;



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2009 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

┌Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23 дугаар зүйлийн 2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон орон нутгийн ээлжит сонгуульд зориулсан төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хуралд болон Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2010 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Лувсанжавт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.



Ч.РАДНАА

070205

Төсөн